



## Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд найрамдах Турк Улс хоорондын хэлэлцээрийн тухай



Бүгд Найрамдах Турк Улстай хийх нийгмийн хамгааллын хэлэлцээрт хоёр улсын Засгийн газрын төлөөлөгчид 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдөр гарын үсэг зурсан ба Улсын Их Хурлаас 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр хэлэлцээрийг соёрхон баталсан.

### А. Хэлэлцээрийн гол агуулга:

Монгол Улс болон Бүгд Найрамдах Турк Улсад шимтгэл төлсөн, төлж байгаа бүх иргэн хамаарах, хоёр улсад тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож тэтгэвэр болон оршуулгын тэтгэмж тогтоох, олгох, тэтгэврийг харилцан шилжүүлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр олгох явдал юм. Хэрвээ даатгуулагч Монгол Улсад тэтгэвэр тогтоолгох бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу, Бүгд Найрамдах Турк Улсад тэтгэвэр тогтоолгох бол Бүгд Найрамдах Турк Улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.

**Жишээ нь:** Монгол Улсын Иргэн “Д” Монгол Улсын нийгмийн даатгалд 14 жил шимтгэл төлсөн, Бүгд Найрамдах Турк Улсад 21 жил ажиллаж, амьдрахдаа Бүгд Найрамдах Турк Улсын тэтгэврийн даатгалд мөн хамрагдсан гэж үзье.

**Хэлэлцээр хэрэгжээгүй цаг үед:** Иргэн “А” нь Монгол Улсын хуулийн дагуу 60 буюу тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн ч, өндөр насны тэтгэвэр авахад шимтгэл төлсөн байвал зохих хугацааны доод хязгаар 20 жилийг хангаагүй учир 12 жилдээ ногдох бүрэн бус хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Хэрэв “А”-ийн Монгол Улсад шимтгэл төлсөн хугацаа 10 жилээс доош байвал нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхгүй.

**Хэлэлцээр хэрэгжиж эхэлснээр:** Иргэн “А” нь Бүгд Найрамдах Турк Улс болон Монгол Улсад шимтгэл төлсөн жилээ нэгтгэн нийт 27 болгон тооцуулж, хоёр орноос тэтгэвэр тогтоолгон авах эрх үүснэ.

1/ Иргэн “А” нь тэтгэврийн нас болон шимтгэл төлсөн хугацааны аль алины хувьд Монгол Улсын хуульд заасан шаардлагыг хангаж буй учир өргөдлөө гаргаж Монгол Улсад өндөр насны тэтгэврээ эхлээд тогтоолгоно. Монгол Улсын Нийгмийн даатгалын байгууллага “А”-ийн 27 жил шимтгэл төлсөн хугацаанд авах тэтгэврийг Монгол Улсад авч байсан цалин хөлснөөс нь бодож, түүнээсээ 12 жилд ногдох хэсгийг Монголын тэтгэврийн даатгалын сангаас сар бүр олгоно.

2/ Бүгд Найрамдах Турк Улсын хуулиар өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх нас эмэгтэй 58 нас, эрэгтэй 60 нас, шимтгэл төлбөл зохих хугацааны доод хязгаар 20 жил байж тэтгэвэр тогтоох учир “А” нь насны хувьд тус улсын хуулийн шаардлагыг хангаж байна. Иймээс иргэн “А” нь Турк Улсын талаас тус улсад шимтгэл төлсөн жилд ногдох хугацаанд авах тэтгэврийн эрх үүсэх юм.

### Б. Ямар төрлийн тэтгэвэр энэ хэлэлцээрт хамаарах вэ?

Дараах төрлийн тэтгэврийг Монгол Улс болон Бүгд Найрамдах Турк Улсын хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

Монгол Улсын хувьд:

- Албан журмын даатгуулагчийн хувьд: өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, оршуулгын тэтгэмж, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн;
- Сайн дурын даатгуулагчийн хувьд: өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, даатгал, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, оршуулгын тэтгэмж, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн.

Бүгд Найрамдах Турк Улсын хувьд:

- Нэг болон түүнээс дээш тооны ажил олгогчтой гэрээ байгуулан ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүний тухайд тахир дутуугийн, өндөр насны, тэжээгчээ алдсаны, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал, жирэмсний болон амаржсаны даатгал,
- Хөдөлмөрийн гэрээгүй, өөртөө ажиллаж байгаа хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тухайд тахир дутуугийн, өндөр насны болон тэжээгчээ алдсаны, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал, жирэмсний болон амаржсаны даатгал,
- Төрийн албан хаагчийн тухайд тахир дутуугийн, өндөр насны болон тэжээгчээ алдсаны тэтгэврийн даатгал.

## Нийгмийн хамгааллын хэлэлцээрийг хэрэгжүүлэгч Монголын талын харилцагч байгууллагын мэдээлэл

1. Байгууллагын нэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам  
Г.Ганчимэг /ХНХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн/  
Цахим шуудан, харилцах утасны дугаар: ganchimeg.g@mlsp.gov.mn, 51-262686

Б.Ундрэм /ХНХЯ-ны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн/  
Цахим шуудан, харилцах утасны дугаар: undram@mlsp.gov.mn, 51-264624

2. Харилцагч байгууллагын нэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар  
Т.Уянга /НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын Олон Улсын хэлэлцээр хариуцсан мэргэжилтэн/  
Цахим шуудан, харилцах утасны дугаар: uyanga.t@ndaatgal.mn, 11-328030 /517/